



126

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

Улсын гуравдугаар төв эмнэлгийн
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Улсын гуравдугаар төв эмнэлгийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Улсын гуравдугаар төв эмнэлэг (Ц.Төмөр-Очир)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 137 тоот тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Н.УДВАЛ

D:\Standart\tushaal.docx

002842

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
11 сарын 14 өдрийн 433 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**П.Н. Шастины нэрэмжит Улсын
гуравдугаар төв эмнэлгийн дүрэм**



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Улсын гуравдугаар төв эмнэлэг (цаашид Төв эмнэлэг гэх) нь улсын хэмжээнд зүрх судасны эмгэг, зүрхний мэс засал, мэдрэл судлалын эмгэг, мэдрэлийн мэс заслын тусламж, үйлчилгээний чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, аргазүйгээр хангах, мэргэжлийн дүгнэлт гаргах лавлагаа төв мөн.

1.2 Төв эмнэлэг нь эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, аргазүйн зөвлөгөөгөөр хангах, хүн амын өвчлөл, өвчний тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага болно.

1.3 Төв эмнэлэг нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.4 Төв эмнэлэг нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.

1.5 Төв эмнэлэг нь П.Н.Шастины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлэг, Монгол улс, Улаанбаатар хот, Ард Аюушийн гудамж-1а гэсэн хаягтай байна.

1.6 Төв эмнэлгийн нэрийг нэрийг англи хэл дээр "Third State Central Hospital" гэж орчуулна.

1.7 Төв эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон санхүүгийн харилцах данс, билэгдэл (лого, сүлд дуу, туг)-тэй байна.

Хоёр. Төв эмнэлгийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв эмнэлэг нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг хамгаалах;
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;
- Үйлчлэгч, үйлчлүүлэгчийн харилцан эрх ашгийг хамгаалах;
- Төрийн хуулийг чандлан сахих.

2.2 Төв эмнэлгийн алсын хараа:

"Үйлчлүүлэгч төвтэй" олон улсын эмнэлгийн тусламж, үйлчилгээний загварыг анагаах ухааны ололт, дэвшилд тулгуурлан үндэсний хэмжээнд бий болгосон, бүс нутаг, дэлхийн түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын эрүүл мэндийн салбарын жишиг эмнэлэг болох.

2.3 Төв эмнэлгийн эрхэм зорилго:

Үйлчлүүлэгч бүрийн хэрэгцээнд нийцсэн чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг эрсдэлгүй, эзлтэй орчинд, үр дүнтэй үзүүлэх.



2.4 Төвийн үнэт зүйлс:

- Хүнлэг, энэрэнгүй сэтгэл;
- Харилцаа, хандлага, ёс зүйн соёл;
- Үйлчлүүлэгч - эмнэлгийн мэргэжилтний харилцан хүндлэл;
- Өндөр үр чадвар бүхий мэргэшсэн баг;
- Үйл ажиллагааны төгөлдөршил;
- Хамт олны харилцан итгэлцэл.

2.5 Төв эмнэлэг нь улсын хэмжээнд дараах чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлнэ:

- Зүрхний эмгэг, зүрхний шигдээсийн үеийн тусламж, үйлчилгээ;
- Мэдрэлийн эмгэг, тархины харвалтын үеийн тусламж, үйлчилгээ;
- Зүрх, судасны мэс заслын тусламж, үйлчилгээ;
- Мэдрэлийн мэс заслын тусламж, үйлчилгээ;
- Судсан дотуурх оношилгоо, эмчилгээний лавлагаа тусламж, үйлчилгээ;
- Зүрх, мэдрэлийн чиглэлийн эмнэлзүйн лавлагаа сургалт
- Гематологи, биохимийн лавлагаа лаборатори
- Зүрх, тархи, мэдрэлийн дүрс оношилгооны лавлагаа төв

Гурав. Төв эмнэлгийн эрх, үүрэг

3.1 Төв эмнэлэг нь дараах эрхтэй:

3.1.1 Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм стандарт, эмнэлзүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2 Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, хүний нөөц, материаллаг бааз, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

3.1.3 Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.4 Судалгаа шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах

3.1.5 Өөрийн орны болон гадаадын төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах;

3.1.6 Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан шийдвэрлүүлэх;

3.1.7 Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.8 Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2 Төв эмнэлэг нь дараах үүрэгтэй:

3.2.1 Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах;

3.2.2 Бусад эрүүл мэндийн байгууллагуудын үзүүлж буй тусламж, үйлчилгээ, оношилгоо, лабораторийн шинжилгээнд чанарын хяналт тавих, мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх;

3.2.3 Тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

3.2.4 Оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамж, аргачлал боловсруулах;

3.2.5 Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, сургалтанд шаардлагатай материаллаг болон хүний нөөцийг бүрдүүлэх;

3.2.6 Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.7 Нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, холбогдох байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах;

3.2.8 Хүн амын өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлж төрийн захиргааны байгууллага болон хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах;

3.2.9 Үйл ажиллагаандаа орчин үеийн мэдээлэл, технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх;

3.2.10 Үзүүлж буй тусламж, үйлчилгээний чиглэлээр эмнэлзүйн судалгаа, шинжилгээг гүйцэтгэж оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох;

3.2.11 Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөр, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх;

3.2.12 Нийт болон зорилтот бүлгийн хүн ам, үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах;

3.2.13 Тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал, гомдолд дүн шинжилгээ хийж, залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах;

3.2.14 Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр болон байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний магадлан итгэмжлэл авах;

3.2.15 Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж, үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх;

3.2.16 Үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдлийн удирдлагын журам боловсруулан хэрэгжүүлэх;

3.2.17 Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.18 Ажлын байрны эрсдлийн үнэлгээг 3 жил тутам хөндлөнгийн байгууллагаар хийлгэх, эрсдлийн удирдлагаар хангаж ажиллах;

3.2.19 Ажиллагсдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.20 Эмч, эмнэлгийн ажилтан, ажилчдад шаардлагатай тохиолдолд хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх;

3.2.21 Хууль тогтоомжид заасан бусад үүрэг

Дөрөв. Төв эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт

4.1 Төв эмнэлгийн удирдлагын тогтолцоо нь Дарга болон түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ.

4.2 Төв эмнэлгийн Дарга нь эмчилгээ, эрдэм шинжилгээ, сургалт, стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн орлогч дарга нар болон захиргааны нэгжийн удирдлагуудыг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.3 Төв эмнэлэг нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, оношилгоо, эмчилгээний удирдамж, стандарт, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, үнэлэлт, дүгнэлт өгөх, нотолгоонд суурилсан эмнэлзүйн анагаах ухааныг хөгжүүлэх үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийг байгуулж, дүрэм, бүрэлдэхүүнийг Дарга батална.

4.4 Төв эмнэлгийн Дарга нь тушаал, Удирдлагын болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл хөтөлнө.

4.5 Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Иргэдийн танхим, Эмэн эмчилгээг зохицуулах хороо болон бусад шаардлагатай зөвлөл, хороод байгуулан ажиллуулна.

4.6 Төв эмнэлгийн Даргын эрх, үүрэг:

4.6.1 Төв эмнэлгийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

4.6.2 Төвийн бүтэц, алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн бизнес төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.6.3 Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төв эмнэлгийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

4.6.4 Орлогч дарга, тасгийн эрхлэгч, төв, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

4.6.5 Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

4.6.6 Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;

4.6.7 Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах, тайлагнах;

4.6.8 Орлогч дарга, төв, албадын дарга, тасгийн эрхлэгч нартай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэх;

4.6.9 Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авлигаас ангид ажиллах;

4.6.10 Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах

Тав. Төв эмнэлгийн санхүүжилт

Төв эмнэлгийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1 Улсын төсөв,

5.2 Эрүүл мэндийн даатгал,


5.3 Үндсэн (төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого, захиалгат үзлэг оношилгоо) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, хууль тогтоомжинд нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж олсон орлого гэх мэт)

5.4 Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж,

5.5 Олон улсын байгуулллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,

5.6 Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа



6.1 Төв эмнэлгийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Төв эмнэлгийн Дарга төлөөлнө.

6.2 Төв эмнэлгийн Даргын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

6.3 Төв эмнэлгийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Төв эмнэлгийн Дарга шийдвэрлэнэ.

6.4 Төв эмнэлэг нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулж ажиллана.

6.5 Төв эмнэлэг нь эрхлэх асуудлын хүрээнд бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төв эмнэлгийн орлогч дарга нарын ерөнхий чиг үүрэг

7.1 Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогыг тодорхойлон, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн бодлоготой уялдуулан, Төв эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.

Эмчилгээ эрхэлсэн орлогч даргын удирдлагад стационари, амбулатори, оношилгооны хэсгүүд хамрагдана. Төрөлжсөн мэргэжлийн оношилгоо, эмчилгээний тасаг, мэргэжлийн төвүүд болон амбулаторийн үйл ажиллагааг уялдуулан, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангана. Эмчилгээний хоол судлалын тасаг болон ариутгал, халдваргүйтгэл, эм зүй, сувилахуйн алба, бусад тасаг нэгжийн гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, уялдаа холбоог хангах, өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ажлын гүйцэтгэл, үр дүнг тооцох, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ажиллана.

Мэс заслын клиникийн удирдагч нь эмчилгээ эрхэлсэн орлогч даргын шууд удирдлаган дор ажиллаж, мэс заслын тасгуудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг тооцох, мэс заслын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах, мэс заслын эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах чиглэлээр чанарын алба, холбогдох тасаг, нэгжүүдтэй хамтран ажиллана.

7.2 Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн орлогч дарга нь Төв эмнэлгийн стратеги төлөвлөлт, хөгжлийн чиг хандлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрүүл мэндийн салбарын болон Төв эмнэлгийн хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхойлох, байгууллагын ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөөг боловсруулах, хяналт-шинжилгээ, үнэлгээг орчин үеийн эмнэлгийн удирдлагын зарчимд нийцүүлэн гүйцэтгэх, байгууллагын стратеги төлөвлөлт, эдийн засаг, даатгал, хүний нөөцийн хөгжил, статистик, мэдээллийн технологийн болон эмнэлгийн тоног төхөөрөмж, хангамж үйлчилгээ, инженер техникийн албадын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, уялдаа холбоог ханган ажиллана. Төв эмнэлгийн гадаад хамтын ажиллагааг хариуцна.

7.3 Эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн орлогч дарга нь Монгол улсын шинжлэх ухаан технологийн хөгжлийн бодлого, дэлхийн хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн эрүүл мэндийн салбарын техник технологи, хүний нөөцийн хөгжлийн цогц бодлоготой уялдуулан Төв эмнэлгийн эрдэм шинжилгээ, судалгааны нэгдсэн бодлогыг тодорхойлж, шат дараатайгаар хэрэгжүүлж, Төв эмнэлгийн бүх түвшний

132

сургалтын бодлого, төлөвлөлт, хяналт, үнэлгээг нэгдсэн удирдлагаар ханган ажиллана.

Эмнэлгийн мэргэжилтний хөгжил, сургалт, судалгаа шинжилгээ, нийгмийн эрүүл мэнд, мэдээлэл сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хариуцсан албадын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг холбогдох эрх зүйн орчинд нийцүүлэн батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, өөрийн хариуцсан ажлын чиглэлээр эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангаж хамтран ажиллах, хүн амын өвчлөл, өвчний тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эмнэлэг, дүүрэг, улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төв эмнэлгийн Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааг хариуцаж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын нэгдсэн санг бий болгох, эмнэлзүйн удирдамж, оношилгоо, эмчилгээний стандартуудыг боловсруулан батлуулах, хэлэлцүүлэх, эмч мэргэжилтний эрдэм судалгааны ажлыг Төв эмнэлгийн нэгдсэн бодлогын хүрээнд хөхүүлэн дэмжиж хамтран ажиллана. Залуу боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх тасралтгүй сургалтын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Найм. Лавлагаа төвүүдийн ерөнхий чиг үүрэг

8.1 Зүрхний төв

Зүрхний төв нь зүрх судасны чиглэлийн тусламж, үйлчилгээг хариуцан ажилладаг тасаг нэгжүүдийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллахаас гадна эрүүл мэндийн салбарын нэгдсэн бодлогын хүрээнд Төв эмнэлгийн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төвийн хөгжлийн төлөвлөгөө, зорилтыг тодорхойлох, эрүүл мэндийн бусад байгууллагуудад лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, зүрх судасны чиглэлийн эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах, алсын дуудлага болон зайн оношилгооны тусламжтайгаар хөдөө орон нутагт шаардлагатай зөвлөгөө, тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, үндэсний хэмжээнд зүрх судасны төрөлжсөн мэргэжлийн тусламжийн бүртгэл мэдээлэл, хяналтын цахим сүлжээг бий болгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.

8.2 Мэдрэлийн төв

Мэдрэлийн төв нь зүрх судасны чиглэлийн тусламж, үйлчилгээг хариуцан ажилладаг тасаг нэгжүүдийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар ханган мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч дэмжин ажиллахаас гадна эрүүл мэндийн салбарын нэгдсэн бодлогын хүрээнд Төв эмнэлгийн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төвийн хөгжлийн төлөвлөгөө, зорилтыг тодорхойлох, эрүүл мэндийн бусад байгууллагуудад лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэдрэлийн тусламжийн чиглэлийн эмч мэргэжилтнүүдийн мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах, алсын дуудлага болон зайн оношилгооны тусламжтайгаар хөдөө орон нутагт шаардлагатай зөвлөгөө, тусламжийг цаг алдалгүй үзүүлэх, үндэсний хэмжээнд мэдрэлийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийн бүртгэл мэдээлэл, хяналтын цахим сүлжээг бий болгон ажиллах зэрэг үйл ажиллагааг хариуцна.

8.3 Дүрс оношилгооны лавлагаа төв

Төв нь эрүүл мэндийн байгууллагуудад дүрс оношилгооны чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дүрс оношилгооны чиглэлийн эмч, мэргэжилтнүүдэд мэргэжлийн холбогдох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, бусад эмнэлгүүдэд зайн оношилгооны тусламжтайгаар Төв эмнэлгийн лавлагаа

133

тусламж үйлчилгээний чиглэлүүдээр шаардлагатай мэргэжлийн зөвлөгөөг цаг алдалгүй, шуурхай үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хариуцна.

8.4 Алсын зайн оношилгооны төв

Эрүүл мэндийн салбарын болон Төв эмнэлгийн хөгжлийн стратегийн хүрээнд зайн оношилгооны чиглэлийг орчин үеийн технологийн дэвшилтэд тулгуурлан хөгжүүлэх, Төв эмнэлгийн үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээг бусад шатлалын эмнэлгүүдэд зайн дамжуулалтын технологид тулгуурлан үзүүлэх, өндөр хөгжилтэй орнуудын хамтын ажиллагаатай эмнэлэгүүдтэй зайн оношилгооны тусламжтайгаар холбогдон мэргэжил, арга зүйн зөвлөгөө, санал солилцох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.5 Эмнэлзүйн ур чадварын төв

Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх үйл ажиллагааг Төв эмнэлгийн хөгжлийн стратеги бодлогын хүрээнд шат дараатайгаар хэрэгжүүлэх, өөрийн эмнэлгийн үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын эмч, мэргэжилтнүүдэд олон улсын стандартад нийцсэн сургалт, арга зүйн техник, технологи, материал хэрэгсэл ашиглан эмнэлзүйн ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах, Төв эмнэлгийн орчин үеийн эмнэлзүйн сургалт арга зүйн баазыг бүрдүүлэн ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллана.

8.6 Эрүүл мэндийн боловсрол олгох төв

Иргэд, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн орчин үеийн сургалтын шинэлэг арга хэлбэрүүдээр эрүүл аж төрөх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэвшлийн талаар мэдлэг олгох, зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх зэрэг чиглэлээр сургалтын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйгээр удирдан явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

8.7 Лавлагаа лаборатори

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлогын хүрээнд Төв эмнэлгийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан лабораторийн тусламж, үйлчилгээний чиглэлээр үндэсний хэмжээнд чанарын баталгаажилтын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, эмнэлзүйн лабораторийн оношилгооны нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллана.

Ес. Төв эмнэлгийн тасаг, албадын ерөнхий чиг үүрэг


9.1 Санхүү, бүртгэлийн алба

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцүүлж, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, архив, бичиг хэргийн хөтлөлтийг зохицуулалтаар хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

9.2 Эмнэлгийн чанарын алба

Албыг хөгжүүлэх стратегийн зорилтыг Төв эмнэлгийн хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан тодорхойлох, чанарын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавих, холбогдох удирдамж, стандартыг мөрдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, төв, тасаг, албадыг чанарын удирдлагын арга зүйгээр хангаж бусад тасаг, албадын үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж хамтран ажиллана.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа тогтмол хийж, үйлчлүүлэгчдийн хэрэгцээг тодорхойлон удирдлагын түвшинд уламжлан шийдвэрлүүлэх, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангахаас гадна Төв эмнэлгийн хэмжээнд лавлагаа мэдээллийн ажлыг хариуцна.



9.3 Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба

Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх, эмнэлзүйн эрсдэлийн бэлэн байдлыг үнэлэх, шаардлагатай үед байгууллагын тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийх, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль тогтоомж, стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж боловсруулах, хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх аудитыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.4 Хангамж, аж ахуй, нөөцийн алба

Төв эмнэлгийн эд хогшил, автомашин, автогараж, барилга, хашааны бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээнд хяналт тавих, удирдлага, зохион байгуулалтаар хангах, эмнэлгийн удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, барилга, сантехник, цахилгаан зэрэг засвар үйлчилгээний шаардлагатай нөөцийн санг бүрдүүлж хяналт тавьж ажиллана. Төв эмнэлгийн эм, урвалжийн нөөцийн нэгдсэн санг бүрдүүлэн эмнэлгийн захиргаа, санхүү, бүртгэлийн албаны хяналттайгаар ажиллах бөгөөд эм, урвалжийн нэгдсэн тооллогыг зохион байгуулах, үр дүнг тооцох, ил тод мэдээлэх, эмнэлгийн удирдлагыг мэдээллээр тогтмол хангах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Төв эмнэлгийн урсгал засвар, төлөвлөгөөт их засварын ажлуудыг зохион байгуулан гүйцэтгэх, хяналт тавих, барилга засварын багийн үйл ажиллагаа, байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зэрэг ажлуудыг хариуцан ажиллана.

9.5 Төрөлжсөн мэргэжлийн тасаг, төв, албад

Төв эмнэлгийн стратеги төлөвлөгөөний хүрээнд нэгжийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төлөвлөх, нэгжийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бусад эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллах, стандарт, удирдамжийн биелэлтийг хангуулах, эмч, мэргэжилтний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх ажлыг холбогдох албадтай хамтран зохион байгуулах, эмч мэргэжилтний тасралтгүй хөгжих үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Ажилтнуудын хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээний биелэлтийг хангуулах, эмч, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар санаачлагатай ажиллана.

9.6 Сувилахуйн алба

Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, Төв эмнэлгийн хөгжлийн стратеги, бодлогод уялдуулан албаны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, чанарыг тасралтгүй дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллана.

9.7 Эм зүйн алба

Төв эмнэлгийн хөгжлийн стратегийн хүрээнд албаны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, төлөвлөх, хэрэгжүүлэх, эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй,

195

эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнүүдийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

9.8 Сургалт, судалгаа, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн алба

Төв эмнэлгийн чиг үүргийн хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах, өвчлөлийн түвшин, тархалтыг тогтоох тандалт судалгаа явуулах, эрт илрүүлгийг хийх, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн болон иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байран дахь болон эрүүл мэндийн чиглэлээр эмч мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагуудтай гэрээний үндсэн дээр сургалт зохион байгуулах, эмч мэргэжилтнүүдийн сургалттай холбоотой асуудлыг зохион байгуулан удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллана.

Төв эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийн судалгаа шинжилгээний ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, судалгааны ажлыг дэмжин чиглүүлж хамтран ажиллана

Байгууллагын эмч, мэргэжилтний мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, хэрэгжилтийг хангах, эмнэлзүйн ур чадварын төв, эрүүл мэндийн боловсрол олгох төвүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.9 Стратеги төлөвлөлт, эдийн засгийн алба

Байгууллагын алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг эрүүл мэндийн салбарын бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, хэрэгжилтийг хангахад шаардагдах санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын жилийн болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авна.


Байгууллагын дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дээрх чиглэлээр байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааг удирдлагаар хангах, даатгалын санхүүжилтийн төлөвлөлт хийх, даатгуулагчдад чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх бодлогыг зохицуулах үйл ажиллагааг хариуцна.

Төв эмнэлгийн өдөр тутмын статистик мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээллэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцах, эмнэлгийн удирдлагыг статистик мэдээллээр хангах, байгууллагын хэмжээнд эмнэлгийн бүртгэл, мэдээллийн талаар сургалт хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргах, статистик мэдээллийн чанарт тогтмол хяналт тавих, сар, улирлын мэдээ тайланг нэгтгэн мэдээлж, үнэн бодит байдлыг хариуцан ажиллана.

9.10 Мэдээллийн технологийн алба

Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого, дэлхийн мэдээллийн технологийн хөгжлийн чиг хандлага, эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн хөгжил, шинэчлэлийн бодлоготой уялдуулан Төв эмнэлгийн мэдээллийн технологийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хөгжлийн стратеги тодорхойлох, үйл ажиллагааны төлөвлөгөөг шат дараатайгаар төлөвлөн хэрэгжүүлэх, мэргэжлийн түвшинд удирдан зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох чиг үүргийг хэрэгжүүлж, үнэн бодит, шаардлагатай мэдээллээр бүх түвшний удирдлагыг ханган ажиллана.

Цахим бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, цахим сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хангах, үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн мэдээллийг холбогдох хууль, дүрмийн дагуу чандлан хамгаалах, эмч, мэргэжилтний мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хариуцан ажиллана.



9.11 Хүний нөөц, хөгжлийн алба нь

Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангалт, хуваарилалт, байршуулалт хийх, Төв эмнэлгийн хөгжлийн стратегитай уялдуулан албаны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөө, байгууллагын соёл, хөгжлийг хангах бодлогыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, шинэчлэх, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэлтийг хангах, багц цагийн баталгаажуулалт хийх, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийг хангах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дээд байгууллага болон өөрийн байгууллагад мөрдөгдөх хууль, дүрэм, журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

9.12 Инженер техникийн алба

Инженерийн байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг төлөвлөх, хэрэгжүүлэх, байгууллагын барилга, сантехник, дулаан, цахилгаан шугам сүлжээ, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тасаг, нэгжүүдийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоод орчны тохижилт, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах зэрэг ажлуудыг хариуцан ажиллана.

9.13 Эмнэлгийн тоног төхөөрөмж, засвар үйлчилгээний тасаг

Эрүүл мэндийн технологийн дэлхийн хөгжлийн чиг хандлага, эрүүл мэндийн салбарын техник, технологийн хөгжил, шинэчлэлийн бодлого, стратегитай уялдуулан эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, технологийн үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд удирдан зохион байгуулах, үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөг шат дараатайгаар төлөвлөн хэрэгжүүлэх, Төв эмнэлгийн хэмжээнд ашиглагдаж буй эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх, чанарын судалгаа, дүгнэлт гарган ажиллах, ашиглалтын байдалд байнгын хяналт тавих, мэргэжлийн засвар үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн судалгааг гарган эмнэлгийн жилийн төсөв, төлөвлөгөөнд тусган ажиллах, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх үйл ажиллагааг хариуцан ажиллана.

9.14 Эмнэлгийн соёл, үйлчилгээний алба

Орчин үеийн эмнэлгийн соёл, үйлчилгээний технологийн дэвшлийг шат дараатайгаар нэвтрүүлэн ажиллах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, гадаад орнуудын эмнэлгийн соёл хөгжлийн туршлагыг өөрийн эмнэлгийн стратеги төлөвлөгөөнд уялдуулан нэвтрүүлж хэрэгжүүлэх, иргэд үйлчлүүлэгчдэд өдөр тутмын эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой мэдээллийг түргэн шуурхай хүргэх, лавлагаа мэдээлэл, тосон, үйлчлэх үйлчлүүлэгчдийн таны туслах үйлчилгээг хариуцна. Төв

157

эмнэлгийн өдөр тутмын цахим мэдээллийн хуудсыг үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан цаг үеийн мэдээллээр баяжуулах, эмнэлгийн цэвэрлэгээ, үйлчилгээг шаардагдах стандартын дагуу гүйцэтгэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, эмнэлгийн халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөн гадаад, дотоод орчны цэвэрлэгээ, үйлчилгээг чанартай гүйцэтгэх, холбогдох стандартын дагуу өдөр тутмын болон төлөвлөгөөт, урсгал, их цэвэрлэгээг батлагдсан графикийн дагуу явуулах, тохижилт, үйлчилгээний ажилд оролцох, орчин үеийн эмнэлгийн орчны тав тух, шийдлийг бий болгох зэрэг үйл ажиллагааг хариуцна.


9.15 Даргын ажлын алба

Удирдах байгууллагын хугацаат албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, Төв эмнэлгийн цаг үеийн тулгамдсан асуудлаар богино хугацаанд хэлэлцэн шийдвэр гаргах, хугацаат болон төлөвлөгөөт үйл ажиллагаанд хяналт тавьж дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Арав. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

Төв эмнэлгийн Даргын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

Мэргэжил, аргазүйн удирдлагаар хангах ерөнхий зураглал



- > Мэргэжил, арга зүйн шууд удирдлага
- - -> Мэргэжил, арга зүйн шууд бус удирдлага



Эрүүл мэндийн сайдын 2013 оны 11... сарын 14 өдрийн 433 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН БҮТЭЦ

